

ХОЁРДОГЧ ХЭЛ, СОЁЛ ЭЗЭМШИХҮЙН АСУУДАЛД

Чой. Баттулга
Лю Динан

Товч агуулга: “Хоёрдогч хэл, соёлыг эзэмшихүй” (Second language and cultural acquisition) хэмээх ойлголт нь сүүлийн үед судалгааны шинэ чиг хандлага болж байгаа учраас монгол хэлийг хоёрдогч хэл болгон суралцагчдад монгол орны байгаль, ахуй, түүх, соёлын мэдлэг олгохоос илүүтэй нүүдлийн ахуй амьдралын мөн чанар, монгол үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлог, ялгаа, соёлын утга учир /код/-ыг агуулж байдаг хэлний болон хэлний бус хэрэглэгдэхүүнийг заан сургах, тэдэнтэй соёл хоорондын харилцан хамаарлын (intercultural communication) түвшинд хамтран ажиллах нь нэн чухал болохыг уг өгүүлэлд онцлон тэмдэглэжээ.

Түлхүүр үг: *Хоёрдогч хэл эзэмшихүй, хоёрдогч хэл, соёл эзэмшихүй, үндэстний сэтгэлгээний онцлог, соёл хоорондын харилцан хамаарал, Монгол орон судлал, тогтвортой хэллэг*

АНУ-ын хэл шинжлэлч Н.Чомскийн (Noam Chomsky) “Түгээмэл хэл зүйн онол” (The Theory of Universal Grammar)-ын хэрэглээний талын тусгал болох “Хоёрдогч хэлийг эзэмшихүйн” (Second Language Acquisition) үзэл баримтлал нь дэлхийн олон улс орны иргэдийн гадаад хэлний боловсролыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр иржээ.

Уг үзэл онолоор, Хүүхэд эхээс хэл сурах байгалийн суурь дэвсгэртэй (Language Acquisition Device LAD) төрдөг. Тэрхүү чадавх нь хүмүүний олон хэлэнд нийтлэг, түгээмэл хэлзүйн судлахуун болсон зарчмуудаас бүрдэл болдог. Тэгж үзэх тохиолдолд хэл сурах үйл нь тодорхой хэлний авиабар, бүтээвэр, үг хэллэг зэрэг хэрэглэхүүнийг хүн тогтоох, нийт хэлэнд түгээмэл байдаг зарчмуудад хандах хоёр зүйлээс бүрдэл болно. Нөгөөтгээгүүр, нялхас хэлд орох, хоёр дахь (хоёрдогч) хэл сурах үйл нь зарчмын хувьд нийтлэг шинжтэй гэж үзэх үндэслэл эндээс мөн урган гардаг байна. (Равдан, 2020:37)

Иймээс “монгол хэлийг хоёрдогч хэл болгон зааж сургахад суралцагчдын төрөлх чадварыг ашиглах нь чухал. Суралцагчид төрөлх хэлээ сурахдаа “мэддэг болсон” хүний хэлний зарчмууд хийгээд төрөлх хэлэнд нь байдаг, гэхдээ төрөлх хэлнээс нь монгол хэлний ялгарах гол ялгааг илтгэж байдаг монгол хэлний хэмжигдэхүүнүүдийг тэдэнд оновчтой “сануулж” зөв хэрэглэж хэвшүүлэн, нэг үгээр “мэддэг зүйл дээр нь” тулгуурлан монгол хэлийг сургавал илүү үр дүнд хүрнэ (Цэрэнпил, 2010:83) гэжээ.

Гэхдээ одоогийн байдлаар Монгол улсад Э.Равдан, Д.Цэрэнпил, М.Ууганбаяр нарын зэрэг эрдэмтдийн судалгааг эс тооцвол монгол хэлийг “хэлний нийтлэг”-ийн үүднээс бүрэн гүйцэд судлаагүй, монгол хэл ба бусад хэлэнд байх нийтлэг зарчим, монгол хэлний бусад хэлнээс ялгарах хэмжигдэхүүнийг (The Principles and Parameters) нарийн тогтоогоогүй байгаа зэргээс шалтгаалан монгол хэлийг хоёрдогч хэл болгон заан сургахад уг үзэл баримтлалыг бараг ашиглаагүй гэж хэлж болно.

Ташрамд, Чомскийн “хоёрдогч хэл эзэмшихүй”-н үзэл баримтлалд шүүмжлэлтэй хандах оролдлогууд, Тухайлбал: “цахимын программаар шүүн тогтоосон өндөр давтамж бүхий хэлний хэрэглэхүүнийг ашиглан түүнд суурилан сургалт явуулах нь суралцагч хүний байгалийн хэлний чадавхыг тулгуур хийхээс илүү үр дүнтэй байдаг (Равдан, 2020:31) гэх Nick C. Ellis-ийн үзэл, нийгэм, соёл нь хувь хүний ухамсар, сурах үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлдөгийг судалдаг Нийгэм соёлын онол (Sociocultural Theory) гарсаар байгааг дурдах нь зүйтэй.

Чомскийн Дотных хэл¹ (Internalized Language) хэмээх ойлголтын хүрээнд ...хүний хэлийг хүний оюун тархины дотоод зүйл..., хэлний мэдлэгийг хүний тархины өмч... хэлний тухай мэдлэг чухам юунаас бүрддэгийг нээн гаргах гол зорилт (Цэрэнпил, 2010:79) болгон судалдаг. Мөн “Түүний дэвшүүлсэн гол санаа нь авиалбар зүй, хэлзүйн хийсвэр тогтолцоо, түүний илэрхийлэл нь хүмүүний уураг тархинд орших бөгөөд тэрхүү хэлний чадавх буюу мэдлэг нь нийгмийн орчноос ангид байна” (Равдан, 2020:257) гэж үздэг учраас энэ үзлийг баримтлагчид тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний соёл, сэтгэлгээний онцлог, ялгаа зэргийг гол болгодоггүй. Гэвч сүүлийн үед хэлийг төгс сайн сурч судлахад хэлний нийтлэг, түгээмэл шинжээс гадна тухайн хэлээр ярилцагч үндэстэн угсаатны соёл, сэтгэлгээний онцлог, ялгаатай шинжийг судлах хандлага маш чухлаар тавигдах болоод байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн “хоёрдогч хэл эзэмшихүй” (Second Language Acquisition) гэдгээс гадна “хоёрдогч хэл, соёл эзэмшихүй” (“second language and cultural acquisition”) гэх ойлголт, судалгааны шинэ чиглэл үүсэн гарчээ.

Энэ талаар анх Монгол улсад эрдэмтэн Ж.Баянсан: Өдгөө хүртэл судалгааны хүрээнд зохих байраа эзэлж чадаагүй, тийм ч учраас сургалтанд ч нэвтрэх боломжгүй үлдсээр ирсэн нэг чухал асуудал бол үндэстний хэл ба тэдний соёлын харилцан хамаарлын тухай асуудал юм. Уг асуудлыг өнгөрсөн зууны хоёрдугаар хагасаас эхлэн Structural anthropology, Social anthropology, Cultural anthropology, Linguoculturology, Ethnolinguistics, Ethnopsycholinguistics зэрэг Хүмүүнлэгийн ухааны салаа салбарт юмуу, эсвэл тэдгээрийн уулзвар дээр судлан тайлбарлах болоод байна. Энэ бол уг асуудлын талаар судалгааны шинэ парадигма үүсэх шаардлагатай болсны гэрч юм. Орчин үеийн өрнө дахины гүн ухааны зарим чиглэл, тухайлбал Hermeneutics болон Transcendent чиглэлийнхний үзэл баримтлалын зарим хэсэг нь уг парадигмад хамаатай болж ирсэн нь санамсаргүй зүйл биш (Баянсан, 2009:42) гэж байсан бол...хэлний зарим үзэгдэл баримтыг хэлшинжлэл, угсаатны судлал, сэтгэцийн хэлшинжлэл, соёлын ба нийгмийн хүн судлал зэрэг Хүмүүнлэгийн ухаануудын уулзвар дээр шинжлэн тайлбарлах зайлшгүй нөхцөлдлөөс үүдсэн судалгааны шинэ парадигмыг бий болгож байна гэж үзүүштэй байна (2016:40) хэмээн нэгэнт бие даасан судалгааны чиглэл болсныг нотлон тэмдэглэсэн байдаг.

Мөн тэрээр “Ямар нэг гадаад хэлийг сурч эзэмшинэ гэдэг бол тухайн хэлийг төрөлх хэлээ болгосон үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал буюу сэтгэлгээний онцлогийг нь зөв таньж ойлгоод, улмаар түүнийг өөрийн унаган соёл, сэтгэлгээний онцлогтой харьцуулж, нийтлэг ба ялгаатай талыг нь зөв илэрхийлж, төгс харилцах арга ухаанд суралцана гэсэн үг гэдгийг төдий л анхаарч байгаагүй юм байна. Ялангуяа харилцаж байгаа хоёр үндэстний соёлын ялгаа хэчнээн их байх тусам түүнийг зөв уялдуулж эзэмших арга зам нарийн түвэгтэй болдог ажээ. Гэвч хэл, соёлын иймэрхүү ялгаатай байдлыг давж туулснаар тухай хүний мэдлэг ухаан анивжиж, сэтгэлгээний цар хүрээ өргөждөг учраас энэ үйл ажиллагаа бол хүний танин мэдэхүйг хөгжүүлэх ач холбогдолтой (Баянсан, 2016:33) хэмээн маш оновчтой тодорхойлжээ.

¹ Д.Цэрэнпил “Internalized Language”-ийг “I хэл”, “Externalized Language”-ийг “E хэл” хэмээн товчилжээ. Цаашид уг нэр томъёог ашиглав.

² “Гадаад хэл, соёлыг аль алины нь тэгш төлөвшүүлэх арга зам” (“second language and cultural acquisition”) Zhang Ailing. (2003) Intercultural Communication, Chu Ban She: Chong Ching Da She, “**Соёлыг цогцлоох үрийг суулгаж өгөх**” (cultivation of “cultural creativity”) Li Zuo Wen, Zheng Zhao Hong (2005) Language and Culture, Hebei University Press.

Иймээс монгол хэлийг хоёрдогч хэл болгон сурч судалж байгаа суралцагчдын хувьд түгээмэл хэрэглэгддэг үгийн сангийн нөөцтэй, дуудлагын хэм хэмжээ, хэлзүйн дүрэм загварыг ягштал баримталж сурахаас гадна монгол хүний сэтгэлгээний онцлогийг зөв таньж ойлгоод, улмаар түүнийг өөрийн унаган соёл, сэтгэлгээний онцлогтой харьцуулж, нийтлэг ба ялгаатай талыг нь зөв илэрхийлж, төгс харилцах арга ухаанд суралцах ёстой юм.

Харин монгол хэлийг хоёрдогч хэл болгон заан сургахдаа, суралцагчдад монгол орны байгаль ахуй, түүх соёлын мэдлэг олгохоос илүүтэй нүүдлийн ахуй амьдралын мөн чанар, монгол үндэстний сэтгэлгээний өвөрмөц онцлог ялгаа, соёлын утга учир /код/-ыг агуулж байдаг хэлний болон хэлний бус хэрэглэгдэхүүнийг эзэмшүүлэхийн зэрэгцээ соёл хоорондын харилцан хамаарлын түвшинд хамтран ажиллах нь нэн чухал болохыг уг онцлон тэмдэглэе.

Бид өмнө монгол хэл суралцагчдад монгол орны байгаль ахуй, түүх соёлын мэдлэгийг сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу олгосоор ирсэн билээ. Уг хөтөлбөр төлөвлөгөөг тухайн үндэстний соёл сэтгэлгээг бүрдүүлж байдаг үндсэн хүчин зүйлүүдэд тулгуурлан боловсруулав.

Үндэстний сэтгэлгээний агуулга, бүтцийг тодорхойлох хэлний бус хүчин зүйлүүд гэвэл:

- тухайн үндэстний аж төрж ирсэн нутаг газрын байгалийн юмсын тогтоц байдал, өөрөөр хэлбэл, цаг уурын онцлог, уул ус, ой мод, хөрс шороо, тэнд ургадаг өвс ургамал, амьдардаг араатан жигүүртний төрөл зүйл,
- тухайн үндэстний эртнээс нааш эрхэлж ирсэн уламжлалт аж ахуй, аж төрөх ёсны онцлог, шашин шүтлэг, ёс заншлын бүх зүйл,
- тухайн ард түмний эртнээс нааш бүтээн цогцдуулж ирсэн уламжлалт эд өлгийн зүйл цөм шууд хамаатай байж, тэр хэлнийх нь тогтвортой хэллэгийн агуулга, утга учрын үндэс болж байдаг ажээ.(Баянсан, 2009:43)

Эдгээрээс суурь хүчин зүйл нь яах аргагүй тэрхүү үндэстний оршин байгаа байгаль газар зүй юм.

Физикч, эрдэмтэн Х.Цоохүү монгол хүний сэтгэлгээний онцлог, ялгааг физик болон байгаль нийгмийн шинжлэх ухааны үүднээс тайлбарласан “Монгол хүн та хэн бэ?” хэмээх сонирхолтой бүтээл туурвисан байдаг. Тэрээр “Хүн төрөхөөсөө эхлээд хүний бүхий л амьдрал нь энэ орон зай дотор явагддаг учраас сэтгэл санаа, үйл хөдлөл, таашаах эс таашаах зүйлс нь ухамсарт үйлдлээс нь үл хамааран орчиндоо аяндаа дасан зохицсон, өвөрмөц онцлогийг нь тусгагдсан байдаг. Байгаль цаг уурын нөхцөл нь бас эрхлэх аж ахуй, амьдрах аргыг нь тодорхойлж өгдөг” (2015:15) гэжээ.

Монгол улсад гадаад хүнд монгол хэл, соёл зааж ирсэн ууган байгууллага болох МУИС-ийн монгол хэлний бэлтгэл анги³-д 1980-аад оны үед монгол хэлний хичээлүүдээс гадна газар зүйн хичээл⁴ орж байсан нь ийм учиртай юм.

³ МУИС-д 1942 оноос эхлэн гадаадын оюутан суралцаж 1971 он хүртэл янз бүрийн мэргэжлээр 226 гадаадын харьяат нар төгсгөснөөс монгол хэлний ангид 1952 оноос гадаад оюутан суралцаж 1971 он хүртэл 29 хүн төгсгөжээ. Энэ хугацаанд гадаадын оюутан, монгол хэлний тусгай бэлтгэл хийлгүй шууд үндсэн ангид орж суралцаж байсан нь тэдний монгол хэл сайн эзэмших, амжилттай суралцахад бэрхшээл учруулж байв. 1970-аад онд манай улсын гадаад харилцаа их өргөжсөнтэй уялдан гадаад орнуудаас манай их дээд сургуульд ирж суралцагч оюутан, мэргэжил дээшлүүлэгчдийн тоо олширч ирэхэд тэдний монгол хэл сургалтын чанарыг сайжруулах талаар цогцолбор арга хэмжээ авах шаардлагатай болов. Эл байдлыг харгалзан “Гадаад оюутны дунд зохиож байгаа хичээл хүмүүжлийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухайн БНМАУ-ын Ардын Боловсролын Яамны сайдын 1971 оны 3-р сарын 30-ны 069 тоот тушаал гарч гадаад оюутан, аспирант, мэргэжил дээшлүүлэгчдийн сургалт хүмүүжлийн ажил хариуцсан тэнхим шинээр байгуулахыг заасныг үндэслэн МУИС-ийн ректорын 1971 оны 6-р сарын 10-ны 230 тоот тушаалаар, “Хэлбичгийн факультетад гадаад оюутны сургалт хүмүүжлийн асуудлыг дагнан хариуцаж байх “Монгол хэлний тэнхим” байгуулсан юм. МУИС-ийн архивын материалаас.

⁴ 1970 оны сүүл 1980 оны эхээр монгол хэлний тэнхимд суралцаж буй гадаад оюутны сургалтын төлөвлөгөөнд 13 хичээл тусгагдаж байв. Үүнээс монгол ярианы хэл, унших үгсийн сан, монгол хэлзүй, бичгийн ажил-авиазүй, найруулах дадлага, эртний монгол хэл, манж хэл, орчуулга зэрэг 8 хичээлийг тус тэнхим хариуцан зааж, төвд хэл, орос хэл, ардын аман зохиол, монголын газарзүй, орчуулгын онол дадлага зэрэг хичээлийг холбогдох

Харин 1990-ээд оноос монгол түүх, газар зүй, соёл, ёс заншлын мэдлэг олгох “Монгол орон судлал” хичээлийг ахмад багш Л.Лхагва, доктор Б.Сарантуяа нар зааж эхэлсэн бөгөөд 2000 оноос доктор Ж.Сэржээ, мөн миний бие зааж байна.

Бид уг хичээлийн агуулгад монгол орны байгаль орчин, монголчуудын ахуй амьдрал, эрхлэх аж ахуй, Монголчуудын оюуны болон эдийн соёл, түүхийн мэдлэгийг олгоход түлхүү анхаарч, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, агуулга арга зүйг шинэчилсэн боловсруулж, ном сурах бичиг бичиж, туршин хөгжүүлэхэд багагүй хугацаа зарцуулсан билээ. Энэ хүрээнд 2006 онд “Монгол орон судлалын унших бичиг”, 2020 онд “Монгол орон судлал” сурах бичгийг туурвисан бөгөөд энэхүү ажил нь монгол хэлийг хоёрдогч хэлээ болгон суралцагчдад суурь хэрэглэгдэхүүн болоод байна.

Харин одоо бид гадаад улсад монгол хэлний мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн анхны байгууллагын нэг Бээжингийн Их Сургуульд монгол орны болон соёлын мэдлэгийг суралцагчдад хэрхэн олгож байгааг өгүүлье.

Бээжингийн Их Сургуулийн монгол хэл, соёлын мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр⁵ 1949 оны 8-р сараас эхэлсэн бөгөөд энэ нь тухайн их сургуулийн гадаад хэлний анхны хөтөлбөрүүдийн нэг билээ.

Хэл соёл нь салшгүй холбоотой, хэл бол соёлын тээгч, соёл бол хэлийг удирдах арга зам юм (Шин Фү И, 1990:88). Энэхүү мэдлэг нь аль хэдийнээ гадаад хэл, соёлын сургалт, судалгаа эрхэлдэг эрдэмтдийн зөвшилцөл байсаар ирсэн. Энэ нь Бээжингийн их сургуулийн “Монгол хэл, соёл” гэсэн мэргэжлийн хөтөлбөрийн нэрнээс тодорхой харагдаж байна.

Мөн хэл соёл хоорондох энэхүү нягт уялдаа холбоог ойлгосны үндсэн дээр 1990-ээд оны эхээр Бээжингийн их сургуулийн монгол хэлний үндсэн ангийн эхний жилд Монгол орон судлал ба соёл⁶, аспирантурын эхний жилд Монгол соёл судлалын хичээлийг ордог болов.

Суралцагчдад монгол хэлний ярих, бичих, унших, сонсох зэрэг хэрэглээний чадварыг сайтар эзэмшүүлэхийн зэрэгцээ монгол хэлтэй холбоотой Монголын ард түмний аж ахуйн хэв маяг, зан заншил, сэтгэлгээний онцлог зэрэг чухал чухал зүйлийг ухааруулан ойлгуулж, соёл хоорондын харилцан хамаарлын (intercultural communication) ур чадварыг дээшлүүлэх замаар монгол хэлийг илүү гүнзгий сургахад уг хөтөлбөрийн зорилго оршино. Сүүлийн жилүүдэд Монгол орон судлал ба соёл хичээлд хамрагдсан оюутнуудаас ирүүлсэн санал хүсэлтийг үзвэл уг хичээл нь суралцагчдад соёлыг ойлгохуйн үндсэн дээр хэлний талаарх ойлголтоо гүнзгийрүүлэхэд нь зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Ингээд, хичээл дээр тохиолддог зарим нэг жишээг сонирхуулъя. Хятад, Монгол хоёуланд байдаг арван хоёр жилийн найм дахь жилийг монгол хэлээр “хонь жил” гэж хэлдэг. Хичээл дээр зарим оюутан “Яагаад “ямаа жил” гэж нэрлээгүй вэ гэж асуудаг. Ингэж асуудгийн учир, хятад хэлэнд хонь ямааг нарийн ялгалгүй, 羊 ханзаар бог малыг нэрлэдэгтэй холбоотой. Харин Монголчууд малыг бэлгэдэл хүндэтгэл, махны чанараар нь: хүйтэн хошуут (тэмээ,

мэргэжлийн тэнхимээр заалгаж иржээ. МУИС-ийн архивын материалаас.

⁵ Уг хөтөлбөрийн дагуу орчин цагийн монгол утга зохиолын хэл-халх аялгуу, кирил монгол бичгийг заадаг бөгөөд монгол бичиг, монголын уран зохиол, соёл, түүхийн талаар үндсэн сургалт, судалгааг явуулдаг. Энэ хүрээнд *Монгол хэл* (халх аялга), *Кирил монгол бичиг*, *Үйгэржсин монгол бичиг*, *Орчин үеийн Монгол уран зохиолын сонгомол уншлага*, *Монгол уран зохиолын түүх*, *Монгол ардын аман зохиол*, *Монгол сонин уншлага*, *Монгол орон судлал ба соёл*, *Монгол улсын түүх* хичээл заадаг. Оюутнуудаас монгол хэлний сонсох, ярих, унших, бичих, орчуулах чадварыг сайтар эзэмшиж, Монгол Улсын нийгэм, түүх, соёл, дипломат харилцаа, улс төр, эдийн засгийн байдлын талаар илүү өргөн, гүнзгий ойлголттой болохоос гадна Хятад болон дэлхийн соёлын талаар харьцангуй өргөн мэдлэгтэй байхыг шаарддаг.

⁶ Энэхүү хичээлийн агуулгын хувьд Монгол орон судлал ба Соёл гэсэн хоёр гол хэсэгт хуваагддаг. Монгол орон судлалын хэсэг нь оюутнуудад Монгол Улсын байгаль орчин, газарзүй, хүн ам, улс төр, эдийн засгийн тогтолцоо ба хөгжил, нийгэм, шашин шүтлэг, соёл гэх мэт зүйлийг ойлгуулах боломжийг олгоход чиглэгддэг. Харин соёлын хэсэг нь Монгол улсын ардын түмний хувцас хунар, идээ ундаа, орон сууц, зам тээвэр гэх мэт аж ахуйн хэв маягтай холбоотой эдийн соёлтой холбоотой агуулга багтдаг. Мөн түүнчлэн монгол хэл, уран зохиол, урлагийн хөгжил, онцлог шинж чанар, баярын өдрүүд, зан заншил зэрэг дээр үндэслэн оюуны соёлын агуулгыг тайлбарлан таниулдаг юм.

ямаа), халуун хошуут (хонь, үхэр, адуу) гэх мэт ангилдаг. Хүйтэн хошуутай малыг хүнд бэлэглэдэггүй. Зөвхөн халуун хошуут малыг бэлэглэдэг гэхээр оюутнууд ойлгоод “аан, ийм учраас Монгол Улсын ерөнхийлөгч Х.Баттулга Хятадын ард түмэнд 30 мянган хонийг бэлэглэсэн нь өлзий сайхан бэлгэдэлтэй байна” гэж шууд ойлгож байна.

Өөр нэг жишээ татвал, "Борооны дараах мөөг" гэсэн монгол хэлц үг бий. Монгол хэл сурч буй хятад оюутнуудад үүнийг орчуулахад "Борооны дараах хулс соёо" гэсэн хятадын үг шууд санаанд нь буудаг. Монгол Улс дэлхийн бөмбөрцгийн хойд тундрийн бүсэд байрладаг бөгөөд хүйтэн уур амьсгалтай, хур тунадас багатай учраас хулс гэдэг ургамал бараг ургадаггүй, Харин зун борооны дараа мөөг их ургадаг. Мөөг ба хулс соёоны хооронд нь харьцуулж хөрвүүлэх нь хоёр орны адилгүй бүс нутгийн цаг уурын нөхцөл байдал, гарц бүтээгдэхүүн, бусад соёлын мэдлэгийг нарийвчлан ойлгосны үндсэн дээр орчуулж чадах болно. Энэ бол хоорондын соёлоор дамжуулан хэлийг гүнзгий ойлгож байгаагийн тод жишээ юм. Иймэрхүү жишээ хичээл дээр байнга тохиолддог.

Энэ мэтчилэн, Монгол төдийгүй монгол хэлний мэргэжилтэн бэлтгэдэг гаднын сургуулиудын хувьд, үндэстний сэтгэлгээний онцлог, соёл хоорондын харилцан хамаарлын тодорхойлох хэлний гол хүчин зүйл болох монгол хэлний тогтвортой нэгжийн утга учрыг тайлан таниулах нь уг хөтөлбөрийн бас нэг зорилго байх ёстой юм. Бид ч мөн нэгж хичээл бүрд яг энэ төрлийн дасгал, гэрийн даалгавар, ямар дадлага ажил хийх зэргийг нь тусгаж өгсөн. Тухайлбал: Монгол орны рашаан, ус сэдэвт 7 дугаар хичээл дэх Унасан газар угаасан ус, Монгол орчин үеийн уран зохиол сэдэвт 30 дугаар хичээлд Б.Лхагвасүрэнгийн “Буруу энгэртэй дээл” шүлгийг сонгосон бөгөөд уг шүлгийн

Унагаж төрүүлээд

Өргөж өсгөсөн

Ээжийнхээ дурсгалд...

гэсэн хэсгийн “Унасан газар”, “Унагаж төрүүлээд” гэсэн хэллэгийг утгыг асуухад төрсөн нутаг гэдгийг төвөггүй ойлгох атлаа яагаад унасан газар, унагаж төрүүлэх гэхээр өөр өөр хэл соёлт хүмүүс “Монголын хөдөө нутгийн газар тэгш биш учраас хүүхдүүд их бүдэрч унадаг” (Япон) “Монголчууд морьтон ард түмэн. Морь унах, мориноос унахтай холбоотой (Польш гэх зэргээр янз бүрээр тайлбарлаж байна. Угтаа энэ нь монгол эх хүний хүүхдээ төрүүлдэг уламжлалтай холбоотой гэх юм уу бусад эх сурвалж: Л.Түдэвийн “Дээшээ доошоо хоёр” эсээний Хүн эхээс төрөхдөө доошоо унаад, дараа нь дээшээ босдог зэрэгтэй холбон тайлбарлахаар сая ойлгож байна. Харин ч “Манай улсад орчин үед бүсгүй хүнийг монголчуудын араг тэвэрч төрдөг лугаа энэ байрлалаар хүүхдээ төрүүлэх нь эх хүүхдийн биед эрүүл мэнд талаас маш сайн гэж үзэх болсон” (Герман) зэрэг монгол дэвшилтэд уламжлалын шинжлэх ухааны үндэслэлийн талаар сонирхолтой зүйл өгүүлж байх жишээтэй.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, Монгол улсад орос, англи, япон, хятад, солонгос зэрэг хэлийг хоёрдогч хэл болгон заан сургах, сурах эзэмшихүйтэй холбоотой эдгээр үндэстний сэтгэлгээний онцлог, соёл хоорондын харилцан хамаарлыг тодорхойлох хэлний болон хэлний бус хэрэглэгдэхүүний судалгаа нэлээн хийгдсэн байдаг боловч монгол хэлийг хоёрдогч хэл болгон заан сургах, сурах эзэмшихүйн талаас ийм төрлийн судалгаа хомс байдаг. Хэдийгээр энэ нь агуулгын хувьд ижил мэт боловч монгол хэл, соёл, монгол үндэстнийг үнэхээрийн сонирхож буй зүгээс хийх учраас онц чухал болно гэж бодож байна.

Номзүй

- Баттулга Ч.** 2020. *Монгол орон судлал*. Уб.
- Баянсан Ж.** 2009. *Хэлний соёл судлал нь монголын судлалын шинэ парадигм мөн*. Монгол судлал. Боть XXX (318), 43 тал
- Баянсан Ж.** 2016. *Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ*. Уб.
- Мөнхцэцэг Н.** *Хэл эзэмшихүй нь байгалийн болоод нийгмийн хүчин зүйлтэй холбогдох нь*. Нийгмийн ухааны салбарын “Хүрэл тогоот-2009” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл, Уб.
- Равдан Э.** 2020. *Хэрэглээний хэл шинжлэл*. Уб.
- Цэрэнпил Д.** 2010. *Хэлний тухай түгээмэл хэлзүйн ерөнхий ойлголтууд*. Оюуны хэлхээ, ЭШБ, Боть II (07) Fasc 10, 83 тал.
- Цоохүү Ц.** 2015. *Монгол хүн та хэн бэ?*. Уб.
- Шин Фү И.** 1990. *Соёл хэл шинжилгээ*. Хубай боловсролын хэвлэлийн газар.
- Бум-Очир Д, Мөнх-Эрдэнэ Г.** 2012. *Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд*.